



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 9/23


Улаанбаатар хот

Г Жендерийн эрх тэгш байдлыг хангах<sup>т</sup>  
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "ж", 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан "Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийн 3.2.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ Нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх "Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбэрийн хэрэгжилтийг ханган ажиллахыг дүүргийн Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар хороо /Б.Болормаа/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ЦОГЦЭЦЭГ

Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн ... оны ... дугаар сарын ... -ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

**“БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ  
ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ”  
ДЭД ХӨТӨЛБӨР  
/2020-2025/**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011 онд батлагдсанаар Монгол улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах тогтолцооны эрх зүйн үндэс бүрдсэн юм. Тус хуулийн 5 дугаар зүйлд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого нь эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах нөхцлийг бүрдүүлэх, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгахад чиглэгдэнэ” хэмээн заасан байдаг.

Энэ хүрээнд Монгол улсын Засгийн газар жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах, жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах үүргийнхээ дагуу 2017 онд 129 дүгээр тогтоолоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” үндэсний хөтөлбөрийг баталсан байдаг.

Тус хөтөлбөрт дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх үүргийг тусгасан ба үүний дагуу дүүргийн Засаг даргын 2018 оны А/173 дугаар захирамжаар дүүргийн Жендэрийн дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажилласан бөгөөд тус ажлын хэсэг Жендэрийн Үндэсний хорооноос томилогдсон зөвлөх багтай хамтран дүүргийн жендэрийн асуудлыг тандан хэрэгцээг тодорхойлох, жендэрийн асуудлыг шийдвэрлэх, жендэрийн бодлого боловсруулахад шаардагдах суурь мэдээллийг бүрдүүлэх зорилгоор “Оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ”-г хийсэн болно.

Багахангай дүүрэг нь хүн амын тоогоор Нийслэлийн 9 дүүргийн дунд хамгийн цөөн бөгөөд засаг захиргааны нэгжийн хувьд 2 хороотойгоор иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна. 2019 оны жилийн эцсийн дүнгээр дүүргийн нийт хүн амын 50.1% нь эрэгтэй, 49.9% нь эмэгтэй байгаа нь хүйсийн хувьд харьцангуй тэнцвэртэй байгааг харуулж байна. Дүүрэгт хөдөлмөрийн насны 2772 иргэн үүнээс эрэгтэй 1404, эмэгтэй 1368 байна. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоонд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ өндөр буюу 61.2%, харин ажилгүй иргэдийн тоонд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр буюу 62.2% байна.

Дүүргийн Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа иргэн 2019 оны байдлаар 113 байгаагийн 56.4% эмэгтэй бөгөөд албан бус хөдөлмөр эрхлэгч 64 иргэн байгаагаас 34 эмэгтэй байна.

Дүүрэгт 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 30 хос гэрлэлтээ шинээр батлуулсан нь өмнөх оноос 6,6 дахин өсч, 6 хос гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх оноос 14,2 дахин буурсан байна. Гэрлэлтээ цуцлуулсан гэр бүлийн 66,6% нь 10 болон түүнээс дээш жил амьдарсан хосууд байгаа нь анхаарал татаж байна.

Багахангай дүүргийн хэмжээнд 2019 онд урьдчилан сэргийлэх үзлэгт 16993, амбулаторийн үзлэг 8193, ор хоног 6145 бүртгэгдэж, 40 ортой эмнэлэг байгуулагдан иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж ажиллажээ. Амбулаторийн үзлэг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд 24.2%-иар буурсан, ор хоног 59.9%-иар, урьдчилан сэргийлэх тарилга 44.7%-иар тус тус өссөн нь халдварт өвчний гаралт нэлээд нэмэгдсэн шалтгаанд дүгнэлт хийж ажиллах шаардлагатай байна.

Эрүүл мэндийн үзүүлэлтээс нэг сайшаалтай үзүүлэлтээс дурьдвал тус дүүрэгт сүүлийн 2 жил эхийн эндэгдэл болон 0-1 насны хүүхдийн эндэгдэл гараагүй нь эрүүл мэндийн чухал үзүүлэлт бөгөөд цаашид бататган ажиллах нь зүйтэй байна.

Шийдвэр гаргах түвшний жендэрийн нөхцөл байдлын хувьд Багахангай дүүргийн удирдах албан тушаалтны 44.4% эмэгтэй, 55.6% эрэгтэй бөгөөд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн 41.1% эмэгтэй, 58.8% эрэгтэй байна. Энэ нь зарим дүүрэгтэй харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Жендерт суурилсан хучирхийллийн нөхцөл байдлын хувьд Улаанбаатар хотын 2019 онд гарсан гэмт хэргийн 0.1 хувь нь Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн нь хамгийн бага хувийн жинг эзэлж байна. Дүүрэгт 2019 оны байдлаар 8 гэмт хэрэгт 4 сэжигтэн яллагдагч холбогдсон ба үүнээс 1 эмэгтэй буюу 12.5%-ийг эзэлж байна. Гэмт хэрэгт өртөж хохирсон 32 иргэний 42% нь эмэгтэй байна. Дүүргийн хэмжээнд 2019 онд эрүүлжүүлэгдсэн 204 хүн байгаа нь өмнөх оноос 70 орчим хувиар өссөнд анхаарах шаардлагатайг харуулж байна

Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд орон нутгийн онцлогт уялдуулан жендерийн асуудлыг бүх түвшинд анхаарах, бүтэц тогтолцоог бүрдүүлэх, жендерийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, үр нөлөө, ойлголт хандлагыг төлөвшүүлэх шаардлагатай байна.

Дүүрэгт жендерийн нэгдсэн бодлогыг батлан хэрэгжүүлснээр дүүргийн хүний нөөцийн бодлого, төсөв, төлөвлөгөөг жендерийн мэдрэмжтэй төлөвлөх, эмэгтэй, эрэгтэй хүмүүст ээлтэй ялгаварлан гадуурхалтгүй орчин нөхцөл бүрдэх, төрийн үйлчилгээг авч буй иргэдийн ялгаатай хэрэгцээг харгалзсан жендерийн мэдрэмжтэй, иргэдийн оролцоо, нийгмийн хариуцлагатай үйлчилгээ хөгжих эхлэлийн суурь тавигдана.

## **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт**

### **2.1 Зорилго**

Дүүргийн бодлого, үйл ажиллагааг жендерийн мэдрэмжтэй төлөвлөх, төсөвлөх, хэрэгжүүлэх, жендерийн эрх тэгш байдлын талаарх олон нийтийн хэвшмэл үзэл буюу сөрөг хандлагыг өөрчлөх, нийгмийн суурь үйлчилгээ, гэр бүлийн харилцаанд жендерийн тэгш байдлыг хангах замаар Жендерийн эрх тэгш байдлыг

хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд энэхүү дэд хөтөлбөрийн зорилго оршино.

## **2.2. Зорилт**

2.2.1 Дүүргийн бодлого, төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах, удирдах болон төрийн албан хаагчдын жендэрийн талаарх эерэг ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлтийг бий болгох талаар сургалтыг үе шаттай зохион байгуулах

2.2.2. Жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл, тэгш бус байдлын үндсэн шалтгаан болсон хэвшмэл ойлголт буюу сөрөг хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалт, сурталчилгааг иргэд, зорилтот бүлэг, олон нийтийн дунд зохион байгуулах, гэр булийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг таниулах арга хэмжээг өрнүүлэх

2.2.3 Дүүргийн хүн ам, гэр бүл, охид хөвгүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд тулгамдаж буй жендэрийн тэгш бус байдлыг арилгахад чиглэгдсэн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах

2.2.4 Дүүргийн шийдвэр гаргах түвшинд ажиллагсдын манлайллыг бий болгох, ур чадварыг сайжруулах, чадавхжуулах чиглэлээр төрийн болон ТББ-тай хамтран ажиллах

## **Гурав. Хэрэгжүүлэх хугацаа**

### **3.1 Хөтөлбөрийг 2020-2025 он хүртэл 2 үе шаттай хэрэгжүүлнэ.**

1. 1-р үе шат 2020-2022 он
2. 2-р үе шат 2023-2025 он

## **Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

### **Нэгдүгээр зорилтын хүрээнд:**

1. Дүүргийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлтөөр шинэчлэн боловсруулж батлуулна.
2. Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудад хийсэн жендэрийн нөлөөллийн үнэлгээний үр дүн, аргачлалыг дүүргийн хэмжээнд танилцуулах, түгээх ажлыг зохион байгуулна.
3. Удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчдад зориулсан жендэрийн танхимиын болон онлайн сургалтыг зохион байгуулна.
4. Байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн дотоод журам, аж ахуйн нэгжийн хамтын гэрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар тусган, жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлтийг бий болгоно.
5. ЕБС, СӨБ-ийн багш, нийгмийн ажилтнуудыг жендэрийн чиглэлээр чадавхжуулах үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулна.
6. Жендэрийн чиглэлээр статистикийн мэдээллийн нэгдсэн сантай болох, хүйсээр ангилсан тоон тайлангийн хэрэглээг холбогдох байгууллага бүрт нэвтрүүлнэ.

- Дүүргийн жендэрийн салбар хорооны ажиллах нөхцөлийг бүрдүүлж, удирдлагаар хангах, асуудал хариуцсан ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчилэн батлуулна.
- Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад жендэр хариуцсан ажилтантай болох ажлыг эхлүүлнэ.

#### **Хоёрдугаар зорилтын хүрээнд:**

- Жендэрийн чиглэлээр иргэдэд зориулан гаргасан гарын авлага, фото болон видео контентыг олон нийтэд түгээнэ
- Иргэд олон нийтэд чиглэсэн жендэрийн хэвшмэл хандлагыг өөрчлөхөд нөлөөлөх сургалт, сурталчилгааны арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, олон нийтийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулна.
- Гэр бүлийн чиглэлээр сургагч багш бэлтгэн, гэр бүлийн төлөвлөлт, үнэ цэнэ, бат бөх байдлыг хадгалах, эхнэр нөхрийн үүрэг хариуцлагын талаар ойлголт өгөх сургалт сурталчилгааг өсвөр үе, залуучууд, залуу гэр бүлд үе шаттай зохион байгуулна.
- Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг таниулах чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчилж алдаршуулна.

#### **Гуравдугаар зорилтын хүрээнд:**

- Жендэрийн тэгш байдлыг хангах зорилгоор гэр бүл, ахмад настан, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй болон өвөрмөц онцлогтой иргэдэд мэдээллийг тэгш хүртээмжтэй хүргэх ажлыг зохион байгуулна.
- Төрийн болон төрийн бус байгууллага, ААНБ-уудад ажилтан хүүхэд хөхүүлэх, ажлын хувцас, дүрэмт хувцас солих өрөөтэй болох, ариун цэврийн өрөөг тусдаа байх зэргээр эрэгтэй, эмэгтэй ажилтны онцлог хэрэгцээнд нийцсэн нөхцөл бүрдүүлнэ.
- Ажил олгогч нь ажилтны гэр бүлийн судалгааг хийж, ар гэрийг тохиромжтой хэлбэрээр дэмжих, ажлын цагийг нягтралж, бүтээмж нэмэгдүүлэх замаар ажилтныг илүү цагаар, амралтын өдөр, цагаар ажиллуулахыг хязгаарлаж хориглох, хорт зуршил бүхий ажилтныг эрүүл амьдралын хэвшилд шилжихэд дэмжсэн орчин бүрдүүлэх зэргээр ажилтны Ажил-ар гэрийн тэнцвэр хангах асуудлыг шийдвэрлэнэ.
- Ажлын байрны бэлгийн дарамт гарахаас сэргийлэх, гарсан зөрчлийг илрүүлэх, шалган шийдвэрлэх механизмыг дотоод журамдаа тусгах замаар үр дүнтэй шийдвэрлэх, буруутанд хариуцлага тооцож, таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Эрүүл мэндийн төвд “Эрэгтэйчүүдийн кабинет” байгуулах ажлыг зохион байгуулж эрэгтэйчүүд, хөвгүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Мэргэжлийн эмэгтэйчүүдийн эмчтэй болж, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

7. Бэлгийн замаар дамжих халдварт-/БЗДХ/-аас урьдчилан сэргийлэх, тусlamж үйлчилгээ үзүүлэх ээлтэй орчинг бурдуулж иргэд ялангуяа эрсдэлт бүлэг, залуучуудын дунд БЗДХ-ын илрүүлгийн ажлыг зохион байгуулна.
8. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийг хүчирхийлэлд өртсэн хүүхэд эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагааг тогтмолжуулж, мэргэжлийн сэтгэл зүйчийг ажиллуулна.
9. Архинаас хамааралтай иргэдийг эрүүл амьдралын идэвхтэй болгон мэргэжил эзэмшиүүлэх, ажлын байранд зуучлах зэрэг арга хэмжээ авч Эрүүл орчин Иргэдийн сайн сайхан дэд хөтөлбөртэй хэрэгжилтийг уялдуулна.

#### **Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:**

1. Дүүргийн хэмжээнд эмэгтэй, эрэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхжуулах, манлайллыг бий болгох чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.
2. Шийдвэр гаргах түвшний хүмүүсийг уулзалт зөвлөгөөн, бие биеэсээ харилцан суралцах, туршлага судлах ажил, арга хэмжээг зохион байгуулна.

#### **Тав. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт**

- 5.1. Дүүргийн хөгжлийн эрх зүйн орчин бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээнд жендэрийн мэдрэмжтэй арга зүй нэвтэрнэ
- 5.2 Дүүргийн хэмжээнд жендэрийн хэвшмэл үзлийн сөрөг үр дагавар багасна.
- 5.3 Жендэрийн ялгаварлан гадуурхалт жендэрт суурилсан хүчирхийлэл, тэгш бус байдал буурна.
- 5.4 Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд тулгарч буй бэрхшээл тэгш бус байдлын саад totgor багасна.
- 5.5 Гэр бүлийн хүрээнд жендэрийн хэвшмэл хандлага багасч гэр бүлийн харилцаанд эерэг өөрчлөлт гарна
- 5.6 Дүүргийн төлөвлөлт жендэрийн мэдрэмжтэй болно
- 5.7 Жендэрийн чиглэлээр хүний нөөц бүрдэнэ

#### **Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт**

6.1 Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бурдуулж, үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

- 6.1.1 Улс болон нийслэл, орон нутгийн төсвийн санхүүжилт
- 6.1.2 Гадаад дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хандив, тусlamж
- 6.1.3 Олон улсын байгууллагын тусlamж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
- 6.1.4 Бусад эх үүсвэр

**Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн удирдлага, зохион байгуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ**

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүүргийн Жендерийн салбар хороо удирдан зохион байгуулна. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр гарган чанаарын болон тоон үзүүлэлтийг ашиглан үр дүнгийн тайланг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан нийслэлийн Жендерийн салбар хороонд танилцуулна.

7.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд гарч буй дэвшил, сорилт болон ил тод байдлын талаарх тайланг дүүргийн вэб сайтад байршуулна..

7.4 Бодлогын үе шатны хэрэгжилтийн үр дүнг 2023 оны эхний улиралд багтаан үнэлж, хоёрдугаар үе шатанд авах арга хэмжээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргана.